

## “ТАНЫГ СОНСЪЁ” АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2018.12.04

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээг шинэ шатанд гаргаж, шийдвэр гаргах түвшинд иргэд, оршин суугчдын саналыг тусган хотын хөгжил, бүтээн байгуулалт, тохижилтын ажилд тэдний оролцоог нэмэгдүүлэх, эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангах зорилгоор 2018 оныг “Иргэдийн оролцоотой амьдрах орчныг сайжруулах жил” болгосонтой холбогдуулан НҮГазар нь “Төрийн албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах жил”-ын хүрээнд хэрэглэгчийн үнэлгээг тогтоох зорилгоор “Таныг сонсъё” аяныг 2018 оны 11 дүгээр сарын 27-30-ны өдрүүдэд НЗЗ-ны 1, 2, 3, 4, 5 дугаар байрууд, НҮНТ-ийн Дүнжингарав, Драгон, Мишээл салбаруудад тус тус зохион байгууллаа.

НҮГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу захиргаа санхүүгийн хэлтсийн дарга Ч.Шинэчимэг, үйлчилгээний албаны дарга Л.Уранхайч, байр ашиглалтын албаны дарга Г.Батзаяа, дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан Т.Итгэл, хууль эрх зүй, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ажилтан Э.Хоролдулам, сантехникийн инженер Б.Доржбалжир, зоогийн газрын менежер С.Алтанцэцэг, нярав Д.Мөнхсайхан, байр хариуцсан менежерүүд тус тус томилогдон, хариуцсан бэлтгэл ажил, зохион байгууллалтад оролцож, тус тусын үүргүүдийг хийж гүйцэтгэлээ.

Ажлын хэсэг НЗЗ-ны байруудад ажиллахдаа:

- Ажилтан, албан хаагчдад НҮГ-ын үйл ажиллагааг танилцуулж,
- Нээлттэй ажлын байрыг зарлаж,
- Санал хүсэлтийг нээлттэйгээр хүлээн авч,
- Сэтгэл ханамжийн судалгааг авч ажилласан.

2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр НЗЗ-ны 3 дугаар байранд ажиллалаа.



Ажилтан, албан хаагчдын гаргасан санал, хүсэлт:

- Ариун цэврийн өрөө бөглөрдөг, ажлын өрөөнд үнэртдэг,
- 508 тоот өрөө маш хүйтэн,
- Цэвэрлэгээ үйлчилгээ маш сайн хийгддэг,
- 3 давхарын цэвэрлэгээ маш сайн байгаа,
- Ажлын байрны орчин нөхцөл сайн, цэвэрлэгээ үйлчилгээ хангалттай сайн,
- 1 дүгээр давхрын цэвэрлэгээ сайн хийгддэг,
- Цахилгаан тасалддаг байснаа больсон. Дахин ийм алдаа гаргахгүй ажиллах,
- Цэвэрлэгээ сайн хийгдэж байгаа. Цаашдаа энэ байдлаа хадгалж ажиллах,

2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр НЗЗ-ны 5 дугаар байранд ажиллалаа.



Ажилтан, албан хаагчдын гаргасан санал, хүсэлт:

А корпус

- Цайны газрын хоолны порцыг нэмэгдүүлэх,
- Цэвэрлэгээ үйлчилгээ сайн,

В корпус

- Цэвэрлэгээ үйлчилгээ хангалттай сайн,
- Байрны дулаан хангамж тун тааруу тул дулаан алдагдлыг бууруулах,
- Өрөөнүүд хүйтэн тул дотоод засал хийлгэх,
- Ажилтан, албан хаагчдын харилцаа, ёс зүй сайн. Ажилчдын ажиллах нөхцөл боломж, илүү цагийн хөлс, амьдрал ахуйг дээшлүүлэх тал дээр анхаарах,
- Слесарь, мужаан дуудахад маш удаан ирдэг,
- Засвар үйлчилгээ хийх шаардлагатай гэж үзэж байна. Цонхнууд дулаан алдагдалтай, дээврээс дусаал гоождог.

2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр НЗЗ-ны 2, 4 дүгээр байруудад тус тус ажилласан ба 4 дүгээр байранд зоогийн газрын амталгааг мөн зохион байгуулсан.



Ажилтан, албан хаагчдын гаргасан санал, хүсэлт:

НЗЗ-ны 2 дугаар байр

- 15 давхрын зоогийн газрын хоолны амт чанар сүүлийн үед сайжирсан,
- Цэвэрлэгээ үйлчилгээ сайн хийгддэг,
- Цахилгаан эрчим хүчийг хэмнэх тал дээр анхаарах,
- ERP системд НҮГ-аас үйл ажиллагаагаа өргөжүүлж, хурлын захиалга авах, санал хүсэлт хүлээн авах, дуудлага хүлээн авах гэх мэт шинэ цэс үүсгэх,
- 501, 509 тоот өрөөнүүд хүйтэн, шалны разеткуудыг далдлах, заримыг нь бөглөх,
- 7 давхрын ариун цэврийн өрөөний хатаагч ажиллахгүй байгаа,
- Өрөөний халаалт муу,

НЗЗ-ны 4 дүгээр байр

- Үйлчилгээний соёл маш сайн, цэвэрлэгээ үйлчилгээнд сэтгэл хангалуун,
- Цэвэрлэгээ маш сайн,
- Шатны аюулгүй байдлыг хангах,
- Харуул хамгаалалтыг сайжруулах,
- 2 давхрын хурлын заалыг ашиглуулах,
- Ариун цэврийн өрөөний үнэрийг арилгах,
- 9 давхрын 00-ын үйлчилгээ маш муу,
- Тамхины цэгийг нэг яаралтай шийдвэрлэх,
- 1 давхрын ариун цэврийн өрөөний ус байнга гоождогийг шийдвэрлэх,
- 6 давхрын ариун цэврийн өрөөнд байнга тамхи татдаг,
- Өвлийн улиралд цонх онгойх боломж бүрдүүлэх,
- Үүдний хаалганд хуулга наах,
- Бохирын шугамнаас үнэр их гардагийг шийдвэрлэх,
- Харуулын ажилтан байнга солигддог байдлыг болиулах,
- Зун халуун, өвөр хүйтэн байна,
- Байрны эмч, бариачтай болох,

- Ажлын цагаар засварын ажил хийхгүй байх,


Мөн аяны хүрээнд НЗЗ-ны байрууд болон, НҮНТ-үүдэд ажиллаж буй ажилтан, албан хаагчдаас НҮГ-ийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой сэтгэл ханамжийн судалгааг хаалттай 8 асуултын хүрээнд явууллаа. Сэтгэл ханамжийн судалгаанд давхардсан тоогоор 358 ажилтан, албан хаагч хамрагдсан.

### Саналын нэгтгэсэн хүснэгт

<b>Цэвэрлэгээ, үйлчилгээний чиглэлээр</b>										
Өрөө тасалгаа болон нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ үйлчилгээ										
	2-р байр /%/	3-р байр /%/	4-р байр /%/	5-р байр "А" /%/	5-р байр "Б" /%/	5-р байр "В" /%/	НҮНТ-ийн Мишээл салбар /%/	НҮНТ-ийн Дүнжингарав салбар /%/	НҮНТ-ийн Драгон салбар /%/	НҮНТ-ийн Оргил салбар /%/
Сайн	91.6	85.4	93.9	100	84.6	94.7	100	100	100	100
Дунд	7.5	14.6	4.5	0	15.4	5.3	0	0	0	0
Хангалтгүй	0.8	0	1.6	0	0	0	0	0	0	0
Үйлчлэгчийн харилцаа болон ажиллаж буй арга барил										
Сайн	96.6	94.5	96.9	89.4	100	94.7	100	100	94.4	100
Дунд	2.5	5.5	1.5	10.6	0	5.3	0	0	5.6	0
Хангалтгүй	0.8	0	1.5	0	0	0	0	0	0	0
Ариун цэврийн ерөөний цэвэрлэгээ										
Сайн	82.3	72.7	86.3	73.6	76.9	84.4	100	100	100	93.3
Дунд	14.2	21.8	12.1	26.4	7.6	15.6	0	0	0	6.7
Хангалтгүй	3.3	5.4	1.6	0	15.5	0	0	0	0	0
<b>Байр ашиглалтын чиглэлээр</b>										
Инженерийн шугам сүлжээний үйл ажиллагаа										
	2-р байр	3-р байр	4-р байр	5-р байр "А"	5-р байр "Б"	5-р байр "В"	НҮНТ-ийн Мишээл салбар	НҮНТ-ийн Дүнжингарав салбар	НҮНТ-ийн Драгон салбар	НҮНТ-ийн Оргил салбар
Сайн	65	60	63.6	22.2	53.8	42.1	85	50	61.1	35.7
Дунд	33.3	36.3	30.3	66.6	23.1	42.1	15	0	22.2	35.7
Хангалтгүй	1.6	3.6	6.1	11.2	23.1	15.8	0	50	16.7	28.6
Дуудлагын үйлчилгээ										
Сайн	71.4	73	75.3	77.7	58.3	61.1	85	88.9	75	70
Дунд	26.8	27	20	22.3	41.7	22.2	15	11.1	18.7	30
Хангалтгүй	1.6	0	4.7	0	0	16.7	0	0	6.3	0
Хурлын заалны тоног төхөөрөмж										
Сайн						60				
Дунд						20				
Хангалтгүй						20				
<b>Зоогийн үйлчилгээний чиглэлээр</b>										

Зоогийн газрын хоолны нэр төрөл, амт чанар										
	2-р байр			5-р байр "А"						
Сайн	48.3			38.8						
Дунд	43.3			50						
Хангалтгүй	8.3			11.2						
Зоогийн газрын үйлчилгээний ажилтны харилцаа, үйлчилгээ										
Сайн	76.5			88.8						
Дунд	21.7			11.2						
Хангалтгүй	1.7			0						
Зоогийн газрын орчин, нөхцөл										
Сайн	83.1			88.8						
Дунд	15.9			11.2						
Хангалтгүй	0.8			0						

### Нэгтгэсэн дүнг графикаар үзүүлбэл:







**НЗЗ-ны байруудын албан хаагчдын өгсөн үнэлгээг харьцуулан үзүүлбэл:**




## Үйлчлэгчийн харилцаа болон ажиллаж буй арга барил




## Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ, үйлчилгээ



## Инженерийн шугам, сүлжээний хэвийн ажиллагаа




## Дуудлагын үйлчилгээ







### НЗЗ-ны 5-р байрны "В" корпусын хурлын заалны тоног төхөөрөмжийн ажиллагаа




### Зоогийн газрын хоолны нэр төрөл, амт чанар



### Зоогийн газрын үйлчилгээний ажилтны харилцаа, үйлчилгээ



### Зоогийн газрын орчин, нөхцөл



Санал асуулгад ороцсон ажилтан албан хаагчдаас зарим санал хүсэлтийг гаргасан:

2-р байр

- Ажлын өрөө, тасалгаа хүйтэн 2
- Лифтны хүрэлцээ муу 2
- Дуудлага удаж ирдэг 1
- Халуун усгүй 1
- Зоогийн газар Е баримт олгох 2
- Хоолны порц бага 3
- Хоолны үнэ өндөр 2
- Хоолны нэр төрлийг нэмэгдүүлэх 2

4-р байр

- 00-ийн өрөөнд тамхи татуулахгүй байх 4
- Ажлын өрөө, тасалгаа хүйтэн 3
- 7 давхарт үйлчлэгч байхгүй 2

5-р байр

- 00-ийн өрөө түлхүүртэй болгох 2
- 00-ийн өрөө үнэртэй 5
- 00-ийн өрөөний почкийг засварлах 2
- Агааржуулалт хийх 1
- Зарим өрөө хүйтэн 6
- Цайны газрын хоол үнэтэй 5
- Сет хоолны меню гаргах 4
- Халуун аарц зарах 3
- Банкны картаар тооцоо хийх боломжтой байх 1
- Е баримт олгох 1
- Хоолны нэр төрөл нэмэх 2
- Хоолны үнийг хямдруулах 6
- Хоолны порц нэмэгдүүлэх 1
- Иргэний танхимын гэрэлтүүлэг муу, поректорын тусгал муу 1

## Дүгнэлт

1. Өрөө тасалгаа болон нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ үйлчилгээнд сайн үнэлгээ өгсөн 333, дунд 23, хангалтгүй 2 үнэлгээг тус тус өгсөн байгаа нь цэвэрлэгээ үйлчилгээнд сэтгэл хангалуун байгааг харуулж байна. Байруудын харьцуулсан графикаас харахад НҮНТ-дэд ажиллаж байгаа албан хаагчид 100% сэтгэл хангалуун байна.

2. Үйлчлэгчийн харилцаа болон ажиллаж буй арга барилын талаарх асуулгад сайн үнэлгээ өгсөн 344, дунд 12, хангалтгүй 2 үнэлгээг тус тус өгсөн байна. Харин НЗЗ-ны байрууд, НҮНТ-үүдийн санал өгсөн байдлыг харьцуулж харахад НЗЗ-ны 5 дугаар байрны “Б” корпус, НҮНТ-ийн Мишээл, Дүнжингарав, Оргил салбаруудад албан хаагчид 100% сэтгэл хангалуун байгаа нь харагдаж байна.

3. Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ үйлчилгээний талаарх асуулгад сайн 301, дунд 46, хангалтгүй 10 үнэлгээг өгсөн нь ихэнх нь сайн үнэлгээ өгсөн боловч өмнөх 2 үзүүлэлтээс доогуур санал байгаа нь цаашид ариун цэврийн өрөөнүүдийн цэвэрлэгээнд анхаарах шаардлагатай байгааг харуулж байна. Байрууд болон НҮНТ-үүдийг харьцуулсан графикаас харахад НЗЗ-ны байруудын ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ үйлчилгээнд анхаарах шаардлагатай байна.

4. Инженерийн шугам сүлжээний хэвийн ажиллагаанд сайн 216, 114 дунд, 27 хангалтгүй үнэлгээ өгсөн байна. Харьцуулсан графикаас харахад НҮНТ-ийн Дүнжингарав, Оргил салбарууд, НЗЗ-ны 5 дугаар байрны “Б”, “В” корпусуудын инженерийн шугам сүлжээний хэвийн ажиллагаанд бусдаасаа доогуур үнэлгээ өгсөн байна.

5. Дуудлагын үйлчилгээний талаарх асуулгад сайн 282, дунд 82, хангалтгүй 10 гэсэн үнэлгээг тус тус өгсөн. Харьцуулсан графикаас харахад НЗЗ-ны 2, 4, 5-р байрны “В” корпус, НҮНТ-ийн Драгон салбарууд доогуур үнэлгээ авсан харагдаж байна.

6. Зоогийн газрын үйл ажиллагаанд НЗЗ-ны 2 дугаар байр, НЗЗ-ны 5 дугаар байрны “А” корпусын ажилтан албан хаагчид санал өгсөн бөгөөд хоолны нэр төрөл, амт чанарт сайн 65, дунд 61, хангалтгүй 12 гэсэн үнэлгээг тус тус өгсөн байгаа нь хоолны амт чанарт сэтгэл дундуур байна.

7. Зоогийн газрын үйлчилгээний ажилтны харилцаа, үйлчилгээний талаарх асуултанд сайн 104, дунд 27, хангалтгүй 2 үнэлгээг тус тус өгсөн байгаа нь дийлэнх нь сэтгэл хангалуун байгааг харууллаа.

8. Зоогийн газрын орчин, нөхцөлд сайн 100, дунд 20, хангалтгүй 3 үнэлгээ өгсөн байгаа нь Хангарди ордны зоогийн газар, Улаанбаатар чуулгын цайны газрын орчин нөхцөлд сэтгэл хангалуун байна.

Судалгааны үр дүнд өгсөн дүгнэлтийн дагуу арга хэмжээ авч, НЗЗ-ны байрууд, НҮНТ-үүдэд ажиллаж байгаа албан хаагчдаас нээлттэй гаргасан санал хүсэлт, сэтгэл

ханамжийн судалгаанд оролцсон төрийн албан хаагчдаас гаргасан санал, гомдолыг тус тус хүлээн авч судлан, шийдвэрлэж ажиллах болно.

ТАНИЛЦСАН: ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ	Х.ЭРДЭНЭБИЛЭГ
ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН: ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА	Ч.ШИНЭЧИМЭГ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА	Л.УРАНХАЙЧ
БАЙР АШИГЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГА	Г.БАТЗАЯА
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН	Т.ИТГЭЛ